



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/272

Улаанбаатар хот

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 12/43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр, “Цэргийн хотхон” орчим ХЕТ-2013-8 багцын “А” хэсэгчилсэн талбайн 28,2 га гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Н.Алтаншагайд үүрэг болгосугай.

2. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажиллахыг Нийслэлийн Орон сууцны бодлогын газар (Б.Ганхүү)-т үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч Б.Сүхбаатарт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

111020001310